



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/25

Шивээговь сум

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг  
дархлаажуулалтын үйл ажиллагааг  
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6,а, 29.1.6.б, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр 11.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 238 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/33 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/05 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/50 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг хуваарилагдаж ирсэн вакциныг тээвэрлэх, хадгалах, дархлаажуулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн их эмч /Ц.Даваасүрэн/-д, зорилтот бүлгийн хүн амыг дархлаажуулах арга хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан газруудыг татан оролцуулж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/, Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/, 2 дугаар багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Отгонбаатар/ нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын байнгын цэгийг Соёлын төвийн зааланд байгуулж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн байгууллагын албан хаагчдыг татан оролцуулж, дархлаажуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэн, хамтарч ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Энхриймаа/, 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч /Б.Даваадолгор/, Соёлын төвийн дарга /Э.Төрмандах/, Шивээ Овоо хувьцаат компанийн гүйцэтгэх захирал /Ц.Энхтүвшин/, Шивээ Сервис ХХК-ийн захирал /Ж.Чинбат/ нарт үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын ач холбогдлын талаар хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулж ажиллахыг сумын Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан (Д.Ууганбат)-д үүрэг болгосугай.

5. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдахыг нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч, албан хаагчдад уриалсугай.

6. Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/50 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.


7. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг сумын Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын ... оны ...р  
сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭГДСЭН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР  
ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Ц.Даваасүрэн – Эрүүл мэндийн төвийн их эмч

Гишүүд:

Д.Отгонжаргал – Засаг даргын Тамгын газрын дарга

С.Отгонбаатар – 2 дугаар багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Шинэбаяр – Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч

Б.Даваадолгор – 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Б.Энхриймаа – Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Э.Төрмандах – Соёлын төвийн дарга

Ч.Энхжаргал – Шивээ Овоо хувьцаат компанийн Хүний нөөцийн албаны дарга

Д.Эрдэнэсүвд – Шивээ Сервис ХХК-ийн менежер

Г.Наранзул – 1 дүгээр багийн их эмч

А.Алтанбагана – 2 дугаар багийн их эмч

Д.Ууганбат – Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан